БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

. . . . . /Ч.ТӨГСДЭЛГЭР/

УЛААНБААТАР ХОТ ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 14, 18 СҮХБААТАР ДҮҮРГИЙН 14 ДҮГЭЭР ХОРОО “СЭЛБЭ ДЭД ТӨВ” ОРЧМЫН ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨН ОРОН СУУЦЖУУЛАХ ТӨСЛИЙН ГАДНА ЦАХИЛГААН ХАНГАМЖ, 110/35/10 КВ-ЫН ДЭД СТАНЦЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 04-р сарын 29-ний өдөр Дугаар:МЗХ2025/09-001 Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого - Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 35 дугаар хурлаар дэмжигдсэн “Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний (концепци) үзэл баримтлал - Монгол улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай”, - Нийслэлийн засаг даргын 2019 оны А/1377 дугаар захирамж “Нам даралтын халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай ” - Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 125 тоот тогтоолоор баталсан Дэд төвүүдийн байршил, талбайн хэмжээг тогтоох тухай тогтоол - Нийслэлийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 2023/11 дугаартай Улаанбаатар хотын “Сэлбэ дэд төв” орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах барилгажилтын төсөл
2.	Зураг төсөл боловсруулах үе шат хугацаа	1 үе шаттай. - Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл Хугацаа - Гэрээнд заасан хугацаагаар
3.	Байршил, газар эдэлбэрийн одоогийн байдал	- Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 14, 18, Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны батлагдсан 158 га талбай - 110/35/10кВ-ын дэд станцын байршлыг тодорхойлж холбогдох байгууллагуудтай зөвшилцөн нарийвчлан тогтоож, захиалагчийн зүгээс газрын эрх баталгаажуулах ажлыг зохион байгуулна.
4.	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	Монгол Улсын хуулиуд: - Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль;

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2025 оны 05 сарын 16 өдөр
СБТ№ 24956 2117401

		- Барилгын тухай Монгол Улсын хууль; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль; - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх хууль; - Бусад холбогдох хууль тогтоомжууд Норм, нормативууд: - Цахилгаан байгууламжийн зураг төсөл, угсралтын дүрэм" БД 43.101.03 - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт БНбД 30-01-04 - Барилгад хэрэглэгдэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНбД 23.01.09/ - Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг угсрах ба төлөвлөх /БНбД 43.102.07/ - 0,4-22 кВ-ын хүчдэлийн хуваарилах шугам сүлжээний дэд өртөө барьж байгуулахад тавигдах шаардлага - 0,4-35 кВ-ын хүчдэлийн хүчний кабель шугам барьж байгуулахад тавигдах ерөнхий шаардлага - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал БНбД 21.01.02 - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНбД 21.02.02 - Захиалагчийн дүрэм УББ12-201-01 - Барилгын орчны тохижилтын ажил БНбД 3.01.06-90 - Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм БНбД 11-04-99 - Орон сууцны хороолол, хотхоны 6-10 кВ-ын сүлжээ болон РП, ТП-үүд /УБЦТС ТӨХК-ийн Техникийн шаардлагын тодорхойлолт:РПТП/, - Бусад холбогдох норм, дүрэм, стандартуудыг мөрдлөг болгох Холбогдох журмууд: - Монгол улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 07-ний өдрийн 68 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм" - Монгол улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 317 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм" - Бусад холбогдох журмууд
5.	Хэрэглэгчийн ачаалал	- Техникийн нөхцлөөр олгогдсон Цахилгааны нийт ачаалал: 45000 кВА - Төлөвлөлтийн нийт ачаалал: Сэлбэ дэд төвийн ТЭЗҮ-ийг үндэслэнэ.
6.	Ажлын зураг төслийн бүрдэл, шаардлага	Иж бүрдэл: - Бэлтгэл ажил (инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зургийн тодруулга) - ЭХЯ-наас олгогдсон 26/2025 дугаартай техникийн нөхцөлийн дагуу 35/10кВ-ын Төгөл дэд станцын 10 кВ-ын хуваарилах байгууламжийн 1, 2 дугаар секцэнд 4 ширхэг вакуум таслуур бүхий ячейк суурилуулж кабель шугам татаж 10 кВ-ын 2ш хуваарилах байгууламжийг барьж тэжээх ажлын зураг төсөл,

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2025 оны 05 сар сарын 16 өдөр
СБТ 24956 2117401

		- Шинээр баригдах 10 кВ-ын хуваарилах байгууламжаас, шинэ орон сууц, барилга байгууламжуудын хэрэглээ, ачаалалд тохирсон хөндлөн огтлол бүхий кабель шугам татаж, шинээр баригдах 10/0,4 кВ-ын дэд өртөөнүүд /ХТП/-үүдийг тэжээх ажлын зураг төсөл, - ЭХЯ-наас олгогдсон 25/2025 дугаартай техникийн нөхцөлийн дагуу 110/35/10кВ-ын 2х40 МВА хүчин чадалтай дэд станцын ажлын зураг төсөл - Техникийн нөхцөлийн дагуу бусад заалтийг мөрдлөг болгон ажлыг зураг төслийг гүйцэтгэх. Зураг төсөлд тавигдах шаардлага: - Зураг төслийн баримт бичиг 4 хувь. Үүнээс: график зураглал CD-ний хамт 2 хувийг захиалагчид, үндсэн хувийг архивт өгнө. - Инженерийн шугам сүлжээний ажлын зургийг UTM-координатын системд хийж гүйцэтгэн батлагдсан ажлын зургийг CD-ээр Хот байгуулалт, хөгжлийн газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэст хүлээлгэн өгөх. - Ажлын зурагт инженерийн бэлтгэл арга хэмжээ, улаан шугам, шугам сүлжээний одоогийн байдал болон төлөвлөлтийг нэг дэвсгэр зураг дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай.
7.	Инженерийн хангамжийн байгууламжийн үндсэн хийцэд тавигдах шаардлага.	Хуваарилах байгууламж, Дэд станц: - Төлөвлөлтийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн чөлөөлсөн талбайд холбогдох норм дүрмийн дагуу байршуулах. - Тухайн хороолол, хотхоныг тэжээж буй дэд станцууд нь ижилхэн, нэг маягийн хийцтэй байх, - Хана, шал, гадна пасадны өнгөний сонголтыг “УБЦТС” ТӨХК-иар хийлгүүлэх - Хуваарилах байгууламж, дэд станц нь кабель шугамын түнелийн В1 давхар, станцын барилгын хаяавчын дагуу кабель сувэгчлэх худагтай байхаар төлөвлөх. - Дээврийн ус хаалгатай хана талруу урсахааргүй байхаар, Хаалга (IP-56) дүйцэхүйц байхаар ажлын зурагт тусгах. - Дэд станц, суурилуулсан тоног төхөөрөмжүүд тэдгээрийн бүтээц нь RM-6 маягийн овор хэмжээ багатай, Диспетчерийн алсын удирдлагын (DAS) системд цаашид холбогдох боломжтой, байхаар зураг төсөвт төлөвлөсөн байх - Шинээр баригдах РП хуваарилах байгууламжуудын 10 кВ-ын I ба II секцээс кабель шугам татаж дэвшилтэт технологи бүхий ХТП дэд өртөөнүүд барьж тэжээх ба цаашид диспетчерийн алсын удирдлагын системд холбогдох боломжтой байх. - ХТП нь үзлэг оношлогоо хийхэд зориулсан 2 талаас ордог хаалгатай, хаалга бүр татуурга болон түлхдэг цоож бариултай, ашиглалтын хугацаанд засвар

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АЖЛЫН АЛБА
20 оны 05 дугаар сарын 16 өдөр
СБТ 24956 2117401

		үйлчилгээ шаардахгүй, байгаль цаг уурын эрс тэс хүнд нөхцөлд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, хэмнэлттэй, хамгийн бага орон зай эзлэхээр байрлуулах боломжтой, үйлдвэрт бүрэн угсрагдсан, барилгын материал нь төмөр карказ бүхий бетон хийцтэй байх. Реле хамгаалалт, автоматик: - РП, ХТП-ны реле хамгаалалт, автоматикт хэрэглэгдэх бүх реле нь Эрчим хүчний салбарын реле хамгаалалтын зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн микропроцессорын реле байна. - Реле хамгаалалтын тэжээл нь гүйдэл, хүчдлийн хосолсон оролттой төхөөрөмжөөс тэжээгддэг. (өөрөөр хэлбэл тэжээлийн үүсгүүрийн хэлбэрээс үл хамаарсан) байна. - Реле хамгаалалтын тэжээлийн төхөөрөмж нь таслуур бүхий хорго болгонд байрлах эсвэл доод тал нь 2кВА дээд тал нь 4кВА хүртлэх чадал бүхий нэгтгэсэн байдлаар суурилуулж болно. Тэжээлийн төхөөрөмж нь таслуур бүхий хорго болгонд тавигдсан тохиолдолд тухайн таслуурыг авааарийн үед таслах чадлын бүрэн боломжтой байхаар сонгогдсон байна. Аль ч тохиолдолд дээрх хосолсон тэжээлийн төхөөрөмж нь өөрийгөө хянах, мэдээлэх функцуудтэй байна. Мөн реле хамгаалалтын тэжээлийн чадлын хүрэлцээг сайжруулах үүднээс хосолмол төхөөрөмжөөс зөвхөн МП реле, таслуурын таслах хэлхээг тэжээж бусад дохиолол болон таслуурын цэнэглэх хэлхээ,залгах хэлхээ зэргийг шууд хувьсах тэжээлээр өгөх шийдэлтэй байхыг зөвшөөрнө. - Хамгаалалтын таслах шат гүйдлийн шууд үйлчлэлийн (таслах үйлчлэл нь дешунтированный буюу таслуурын 5А-ын гүйдлийн ороомгоор тасардаг) байна. - 10 кВ-ын гүйдлийн трансформатор нь реле хамгаалалт болон хэмжүүрийн зориулалт бүхий тусдаа хоёр ороомогтой, хэмжүүрийн ороомгийн нарийвчлалын анги нь 0,5 байна. Оролт, секц холбогч болон гаргалга шугамын таслуурын хоргоны гүйдлийн трансформатор нь фаз тус бүрт тавигдана (3ш). - Хуваарилах байгууламжуудын Схем горимыг “УБЦТС” ТӨХК-тай зураг төслийн шатанд зөвшилцөх. 10 кВ-ын кабель шугам: - Ачаалалд тохирсон хөдлөн огтлол бүхий кабель шугам татаж, шинэ дэд станцуудыг тэжээх - Хэрэглэгчийн хэрэглээ, ачаалалтай уялдуулан кабель шугам, трансформаторуудын хүчин чадлыг тооцоогоор сонгох

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2025 оны 05-р сарын 16-ны өдөр
СБТ№ 24956 2117401

		- Кабелиуд 10 кВ-ын хүчдэлийн түвшинд ашиглах, орчны температур -15 хэм байхад угсралт хийх боломжтой байх - Цахилгааны шугам, тоноглолуудыг орчин үеийн дэвшилтэт техник, технологийн шийдлийг тусгасан, байгаль орчинд ээлтэй байхаар сонгох 110кВ-ын ЦДАШ, 131,132,137,138-р ЦДАШ-ын дамжуулагч утас солих: - Цахилгаан дамжуулах агаарын шугамын утасны хөндлөн огтлолыг ачаалалд тохирсон тооцоогоор сонгож, аянгын тросс, шилэн кабельтай байхаар зураг төсөлд тусгах - Цахилгаан дамжуулах агаарын шугамын түлугуурын үндсэн хийц нь төмөр, төмөр бетонон байх - 220/110/35 кВ-ын “Сонгино” дэд станц болон 110/35/10 кВ-ын “Найрамдал” дэд станцыг холбосон 110 кВ-ын 131,132-р ЦДАШ - 220/110/35 кВ-ын “Улаанбаатар” дэд станц болон 110/35/10 кВ-ын 110/35/10 кВ-ын “Сэлбэ” дэд станцыг холбосон 110 кВ-ын 137,138-р ЦДАШ - 110 кВ-ын 131,132,137,138-р ЦДАШ-ын дамжуулагч утсыг дэвшилтэт технологи бүхий өндөр дамжууламжтай дамжуулагч утсаар солих - Хэвийн, засварын, аваарийн горимуудад техник эдийн засгийн ба механикийн тооцоонуудыг үндэслэн дамжуулагч утасны төрөл болон хөндлөн огтлолыг сонгох - Шинээр солих дамжуулагч утас нь одоо ашиглаж байгаа АС-240/39 маркийн дамжуулагч утаснаас гүйдэл нэвтрүүлэх чавдар өндөртэй, олон улсын IEEE стандартын шардлага хангасан байх - Тусгаарлагчийн тоо, төрөл, материалын сонголтыг норм дүрэмд нийлүүлэн сонгох - Шинэ 110 кВ-ын дамжуулагч утас, хөндийрүүлэгч элементүүд, утасны угсралтын тоног төхөөрөмжүүд нь олон улсын стандартын шаардлага хангасан байх, монгол улсын байгаль цаг уурын, тухайн газар орчны нөхцөл онцлогуудыг харгалзан зураг төсөлд тусгах - Техникийн нөхцөлд тусгасан бусад шаардлагуудыг зураг төсөлд тусгах 110/35/10кВ-ын дэд станц - ЭХЯ-аас олгогдсон 25/2025 дугаартай техникийн нөхцөлд тусгагдсан заалтуудыг мөрдлөг болгон гүйцэтгэх - 110 кВ-ын 135, 136-р ЦДАШ-аас салбарлуулан, шинээр цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, 110/35/10 кВ-ын дэд станцыг тэжээх - Дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламж нь I, II систем шинтэй, орж гарсан шугамын 4 таслуур, хүчний трансформаторын 2 таслуур, секц холбогчийн 1 таслууртай байхаар шийдэх зураг төсөлд тусгах - Дэд станцын 35 кВ-ын ИХБ нь секцлэгдсэн нэг систем шинтэй байх, - 35 кВ-ын I, II систем шин нь трансформаторын 2 оролттой, секц холбогч таслууртай байх, 2

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
БҮТЭНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2025 оны 05 сарын 16 өдөр
СБТА 24956 2117401

		гаргалгаатай байх бөгөөд цаашид 2 гаргалгаагаар өртгөх зай талбайг зурагт тусгах, - 10 кВ-ын ХХБ нь секцлэгдсэн шинтэй, оролтын 2, дотоод хэрэгцэээий трансформаторын 2, хүчдэлийн трансформаторын 2, секц холбогч таслуурын 1, секц холбогч салгуурын 1, компенсацлах реакторын 2, гарсан шугамын 22, нийт 32 ячейктай байх, секц тус бүрт нөөц гаргалгаа төлөвлөж зай талбайг тооцох - Дэд станцын дотоод хяналтын системмийг байгуулсан, ДҮТ ТӨХХК-ийн Хяналт мэдээллийн системд холбосон, диспетчерийн шуурхайг холбоог зураг төсөлд тусгах - Цахилгаан дамжуулах агаарын шугам тоноглолын реле хамгаалалт, системийн автоматикийн сонголтыг ЦДҮС ТӨХК-тай зөвшилцөх, тавилын тооцоог ДҮТ ТӨХХК-тай зөвшилцөх - Дэд станцын тоолууруудыг тоолуурын нэгдсэн системд холбосон зураг төсөл боловсруулах - Тооцоогоор сонгосон тоног төхөөрөмжүүд нь монгол улсын болон олон улсын техникийн хорооноос гаргасан стандартуудыг хангасан байх - Дэд станцад шинээр суурилуулах тоноглолууд нь олон улсын стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын үндсэн болон бэлтгэл хамгаалалтыг холбогдох богино залгааны тооцоонуудыг хийж сонгох - Техникийн нөхцөлд тусгасан бусад шаардлагуудыг зураг төсөлд тусгах
8.	Инженерийн хангамж	- Инженерийн бэлтгэл арга хэмжээ: Шинээр хийх болон одоо байгаа далан сувагт ус зайлуулах системийг холбоно. - Дулаан хангамж: Төвлөрсөн болон бие даасан дулаан хангамжийн шугам сүлжээнээс хангагдана. - Усан хангамж: Төвлөрсөн болон бие даасан усан хангамжийн шугамаас хангагдана. - Ариутгах татуурга: Төвийн болон бие даасан усны шугамд холбогдоно. - Мэдээлэл холбоо, дохиолол: Улаанбаатар хотын мэдээлэл холбооны нэгдсэн сүлжээнд холбох; - Мэдээлэл холбооны худаг сувагчлалын байгууламж, газрын шилэн кабель агаарын баганат шугамаас нормын дагуу зай авах; - Авто зам: Хотын болон хорооллын замтай холбоно. - Ногоон байгууламж: Явган зам талбай, нийтийн эзэмшлийн талбайг Барилгын тухай хуулийн 10.1.4 дүгээр заалтыг мөрдөж төлөвлөнө.
9.	Шугам сүлжээний трасс сонголтонд тавигдах шаардлага	- Авто зам, төмөр зам, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоох, - Бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөсөн ажлын зурагтай уялдуулах. - Трассанд өртөж байгаа нэгж талбаруудыг зурагт тэмдэглэж, газар чөлөөлөлтийн зардал тооцон төсөвт тусгах, холбогдох байгууллагуудтай зөвшилцөх

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2025 оны 05 сарын 16 өдөр
СБТА 24956 2117401

10.	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Эдийн засгийн тооцоог УББ 80-204-16 “Хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцох заавар”-аар, төсвийг БНбД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн програмаар тооцно. - Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан төсвийг үе шаттайгаар тооцох
11.	Зураг төсөл боловсруулах хугацаа	- Гэрээнд заасан хугацаанд
12.	ТЭЗҮ, зураг төсөл, төсөв боловсруулах байгууллага	- Эрчим хүчний барилга байгууламжийн ТЭЗҮ болон ажлын зураг төсөл боловсруулах зохих тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий хуулийн этгээд байна.
13.	Төслийн захиалагч	- Сэлбэ 20 минут хот корпорац ХХК
14.	Галын аюулгүй байдлын нөхцөл	- Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал БНбД 21-01-02 - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНбД 21-02-02
15.	Байгаль орчны үнэлгээ нөхцөл	Шаардлагатай тохиолдолд байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэх
16.	Онцгой нөхцөл (Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи хэрэглэх гэх мэт)	- Ажлын зураг гүйцэтгэх явцад ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК, ЦДҮС ТӨХК болон бусад инженерийн шугам сүлжээний хангагч байгууллагатай газар дээр нь үзэж судлах, - Шугам сүлжээ болон түүнтэй холбогдох барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх. - Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөлтэй уялдуулах. - Цахилгааны шугам сүлжээ авто зам доогуур оглох хэсэгт нэвтрэх сувагтай байхаар төлөвлөж зураг төсөвт тусгах, - Цахилгааны шугамын трассын дагуух тохижилт, нөхөн сэргээх ажлын зардлыг төсөвт тооцож тусгах.

ЗӨВШӨӨРСӨН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.БАЯРСАЙХАН

ХЯНАСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ЛХАМСҮРЭН

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Б.ЭРХЭМЗАЯА

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2025 оны 05 сарын 16 өдөр

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Т.МӨНХБОЛД

БОЛОВСРУУЛСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ОРГИЛ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР

ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА

2016 оны 05-р сарын 16 өдөр

СБТ№ 24956 2117401

БАРИЛГАЖИХ ТАЛБАЙН СХЕМ ЗУРАГ

(Дугаар: 2025/09-001 Архитектур төлөвлөлтийн даалгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Чингэлтэй дүүргийн 14-р хороо, 18-р хороо	Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК	Цахилгааны шугам, Дэд станц

5



Масштаб 1:10000 *Тусгаг: EPSG:32648* *(Архитектур төлөвлөлтийн даалгаврын хамт хүчинтэй.)*

ТАНИХ ТЭМДЭГ

- *Одоо байгаа барилга*
- *Төлөвлөлтийн хязгаар*
- *Нэгж талбар*
- *Цэвэр усны шугам*
- *Бохирын шугам*
- *Дулааны шугам*
- *Холбооны шугам*
- *Усны шугам*
- *Төлөвлөлтийн Цахилгааны шугам*

ТОДОРХОЙЛОЛТ

1	*Төлөвлөж буй байршил*
2	*Төлөвлөж буй 110/35/10кВ-ын дэд станц*
3	*7 буудлын автобусны буудал*
4	*Оргил худалдааны төв*

ОЛГОСОН ТАЛБАЙН ТОДОРХОЙЛОЛТ

Эдэлбэр газар (м²)	
Барилгажих талбай (га)	158

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН [illegible]

ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦО

ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА

2025 оны 09 сарын 16 өдөр

СБТ 24956 2117401

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс	Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Арцатын ам /17100/, Наадамчдын зам 1200 Цахим хуудас: www.uda.ub.gov.mn, www.ebarilga.ub.gov.mn Утас: 72707700